



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 10 өдөр

Дугаар Б/07

Өмнөдэлгэр сум

Д.Дариймийг ажилд томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2 дах заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.1, 145.2 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дах заалт, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240, 241 дугаар тогтоол, байгууллагын дотоод журмын 13.1, 13.4 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орос хэлний багшаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоогдсон Дондогийн Дариймийг орос хэлний багш дутагдалтай байгаа байдлыг харгалзан 2025 оны 02 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн орос хэлний багшаар түр томилсугай.

2. Багш Д.Дариймийн үндсэн цалинг хөдөлмөрийн гэрээг үндэслэн 2,077,600 (хоёр сая далан долоон мянга зургаан зуу) төгрөгөөр тогтоосугай.

3. Багш Д.Дариймд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, багшийн ёс зүйн болон байгууллагын дотоод дүрэм журмыг чандлан сахиж хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

**ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.СУГАРРАГЧАА**

